



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО  
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991  
Affiliated to FINA, 1996  
Affiliated to AASF, 2000

2025 оны 03-р сарын 25-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

“МУССХ-ны шүүгч, улсын шүүгчийн зэрэг цол олгох журам”,  
улсын шүүгчид нэр дэвшигчдийг батлах тухай

“Монголын усан спорт сонирхогчдын холбоо” төрийн бус байгууллага (“Холбоо” гэх)-ын Удирдах зөвлөлийн хурлаас Холбооны дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.7.10-т Удирдах зөвлөл нь “Байгууллагын дотоод журам батлана”, 11.7.8-д “Шагнал урамшуулалд нэр дэвшигчийг батлана” гэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

- Холбооны “Шүүгч, улсын шүүгчийн зэрэг цол олгох журам”-ыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
- “МУССХ-ны шүүгч, улсын шүүгчийн зэрэг цол олгох журам”-д заасан шаардлагыг биелүүлсэн Г.Галбадрах, М.Аюуш, Б.Энхжин нарт усанд сэлэлтийн спортын “Улсын шүүгч” цол олгосугай.
- Тус журмыг Холбооны бүх гишүүдэд сурталчлан таниулах, мөрдлөг болгон ажиллахыг Холбооны УЗ-ийн дэргэдэх Шүүгчдийн зөвлөл болон ЕНБД М.Энхбаатарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Батсайхан

П.БАТСАЙХАН



## МУССХ-НЫ ШҮҮГЧ, УЛСЫН ШҮҮГЧИЙН ЗЭРЭГ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо (цаашид “Холбоо гэх”)- ны шүүгчийн зэрэг, цол олгох болон мэргэжлийн ур чадварыг үнэлэх аргачлалтай холбоотой бүх үйл ажиллагааг зохицуулах бөгөөд шүүгчийн чадвар, туршлага, ёс зүй, практик мэдлэгийг тогтмол үнэлж, энэ үйл явцад стандарт, хяналт тавих үүрэгтэй байна.
- 1.2. Холбоо нь шүүгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, шударга, ил тод, ёс зүйтэйгээр шүүлтийн үйл ажиллагааг явуулахад анхаарал хандуулан ажиллана.
- 1.3. Шүүгч нь зөвхөн онолын мэдлэг, ур чадвар төдийгүй ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн хандлага, олон талт ур чадвараа хөгжүүлэхэд анхаарах ёстой.
- 1.4. Энэ журмын дагуу Холбооны шүүгчийн зэрэг, цол олгох, улсын шүүгчийн шалгуур хангах шаардлагууд нь зөвхөн Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шүүгчдэд хамаарна. .

### ХОЁР. Зорилго

- 2.1. *Шүүгчийн тоог нэмэгдүүлэх:* Холбооны болон улсын шүүгч нарын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, шүүгчийн ажиллах орчныг сайжруулах замаар чадварлаг шүүгчдийн тоог нэмэгдүүлэх.
- 2.2. *Улсын шүүгч нарыг бэлтгэх, хөгжүүлэх:* Улсын хэмжээний мэргэжлийн шүүгчдийн нөөц тодорхой хугацаанд нэмэгдүүлж, шүүгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх замаар олон улсын зэрэглэлтэй тэмцээнүүдэд оролцох нөхцлийг бүрдүүлэх.
- 2.3. *Шүүгчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх, нэмэгдүүлэх:* Усны спортыг хөгжүүлэхийн тулд шүүгчдийн мэдлэг, ур чадварыг байнга сайжруулах шаардлагатай. Энэ журмын хүрээнд шүүгчдийг олон улсын стандартын дагуу сургалтанд хамруулж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлнэ.
- 2.4. *Шударга, ил тод үйл ажиллагаа:* Шүүгчдийн үйл ажиллагаанд шударга ёс, ил тод байдлыг хэвшүүлэх.



2.5. Ёс зүй: Шүүгч нь ёс зүйн хэм хэмжээг баримтлан, шүүлтийн үйл ажиллагаанд өндөр хариуцлагатай хандана.

2.6. Стандарт, дүрэм, журам: Монгол улсын шүүгч нь зөвхөн дотоодын стандарт, дүрэм журам төдийгүй "World Aquatics"-ын дүрэм журам, үзэл баримтлалд нийцсэн үйл ажиллагаа явуулна.

### **ГУРАВ. МУССХ-ны Шүүгч болоход тавигдах шаардлага**

3.1. Холбооны шүүгчийн сургалтанд хамрагдсан байх.

3.2. Холбооны шүүгчийн сургалтанд хамрагдаж, дүрмийн шалгалт өгч, шалгалтын оноо 80-аас дээш авсан тохиолдолд шүүгчийн цол олгоно.

### **ДӨРӨВ. Улсын Шүүгч болоход тавигдах шаардлага**

4.1. Холбооны шүүгч байх

4.2. Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны нэгдүгээр шатны шүүгчийн сургалтанд хамрагдсан байх

4.3. Шүүгчийн туршлага: Насанд хүрэгчдийн УАШТ, Өсвөр үе-залуучуудын УАШТ, Мастерсийн УАШТ, Ерөнхийлөгчийн цомын тэмцээнд Ерөнхий шүүгч, Нарийн бичиг шүүгч, Техникийн шүүгч, Зохион байгуулагч шүүгч, Цагчин шүүгч, Хяналтын шүүгч, Гарааны шүүгч, Эргэлтийн шүүгчийн байрлалд ажилласан байх.

4.4. Журмын 4.3 заасан шүүгчийн тэмцээний байрлалаас хамаарах үнэлгээг дараахи байдлаар тогтооно. (Хавсралт-1)

4.5. Ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа Ёс зүйн хэм хэмжээг зөрчиж, шийтгэл хүлээгээгүй байх. Холбооны Ёс зүйн дүрмийн шаардлагатай танилцсан байх.

4.6. Холбооны Шүүгчдийн зөвлөлийн доорхи чиглэлээр гаргасан дүгнэлтүүдийг Улсын шүүгчийн шаардлагын нэг хэсэг болгон авч үзнэ. Үүнд:

- Онолын мэдлэг болон туршлага: Шүүгч нь усан спортын дүрмүүд, хууль эрх зүйн орчныг бүрэн ойлгож, шинэчлэлтүүдийг дагаж мөрдөх шаардлагатай.
- Шүүгч нь өөрийн ур чадвараа сайжруулж, шударга, үндэслэлтэй шийдвэр гаргах чадвартай байх.



- Багаар ажиллах болон хамтын шийдвэр гаргах чадвартай байх.
- Тэмцээний зохион байгуулалт, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл зэрэг олон талын мэдлэгтэй байх.

### ТАВ. Оноо баталгаажуулах

- 5.1. Шүүгч нь тэмцээний өмнө Холбоотой Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах бөгөөд гэрээнд тухайн шүүгчийг ямар албан тушаал дээр ажиллахыг тодорхой зааж өгөх бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд 4.4-т заасан оноог тооцохгүй болно.
- 5.2. Шүүгч тэмцээн эхлэхээс 1 цагийн өмнө “Шүүгчдийн бүртгэлийн хуудас”-нд гарын үсэг зурах бөгөөд тус хуудсанд шүүгч нь тухайн өдөр ямар албан тушаал дээр ажиллахыг заасан байна. (Хавсралт-2). Энэхүү хавсралт нь шүүгчийн онооны үнэлгээг тооцох гол баримт бичиг болно.
- 5.3. Тэмцээний протоколын дагуу Ерөнхий шүүгч нь шүүгчдийн ажлын байрлалыг тогтооно.

### ЗУРГАА. Бусад

- 6.1. Холбооны Шүүгчийн зэргийг Холбооны Шүүгчдийн зөвлөл, Улсын шүүгч цолыг Холбооны Шүүгчдийн зөвлөлийн саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн шийдвэрээр олгоно.
- 6.2. Холбооны шүүгчид үнэмлэх, Улсын шүүгчид Үнэмлэх, энгэрийн тэмдэгтэй олгоно.
- 6.3. Журмын шаардлагыг биелүүлсэн байдал нь баримтаар нотлогдож байгаа тохиолдолд журам батлагдахаас өмнөх ажилласан байдлыг үнэлэн энэхүү журмыг хэрэглэн шүүгчийн зэрэг цол олгож болно.



Хавсралт 1



Хавсралт 1

### Шүүгчдийн үнэлгээний хүснэгт

Д/Д	Шүүгчийн албан тушаал	Үнэлгээ
1.	Ерөнхий шүүгч	2 оноо
2.	Гарааны шүүгч	2 оноо
3.	Хяналтын шүүгч	1 оноо
4.	Нарийн бичгийн шүүгч	1 оноо
5.	Техникийн шүүгч	1 оноо
6.	Зохион байгуулагч шүүгч	1 оноо
7.	Цагчин шүүгч	1 оноо
8.	Эргэлтийн шүүгч	1 оноо



**Шүүгчдийн бүртгэлийн хуудас (Тэмцээний нэр)**

№	Ажиллах байрлал	Шүүгчийн нэр	Огноо	Урьдчилсан гараа	Финал
1.	Ерөнхий шүүгч			Гарын үсэг	Гарын үсэг
2.	Гарааны шүүгч				
3.	Хяналтын шүүгч				
4.	Нарийн бичиг шүүгч				
5.	Техникийн шүүгч				
6.	Зохион байгуулагч шүүгч				
7.	Цагчин шүүгч				
8.	Эргэлтийн шүүгч				